

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	14
3.5.1 Мөнгөн хөрөнгө	14
3.5.2 Авлага.....	14
3.5.4 Урьдчилгаа	15
3.5.6 Бараа материал	16
3.5.7 Үндсэн хөрөнгө.....	17
3.5.8 Өр төлбөр	17
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо.....	18
3.5.10 Орлогын данс.....	19
3.5.11 Зардлын данс.....	19
3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	20
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	21
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	22
4. Менежментийн захидал	23
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ШУТС	Шинжлэх ухаан технологийн сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал зуучлалын яам
УГЗ	Урьдчилж гарсан зардал
ТББ	Төрийн бус байгууллага
ХААДС	Хөдөө аж ахуйг дамжих сан
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААЯ	Хүнс Хөдөө аж ахуйн яам
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай компани
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ М.ТУНГАЛАГ
ТАНАА

2021.03.25 № 01/1005
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухаан технологийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийж гүйцэтгэлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Шинжлэх ухаан технологийн сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шинжлэх ухаан технологийн сан нь тайлант онд Бодлогын баримт бичигт тусгагдсан 3 арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 10 арга хэмжээ, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 4 зорилтын 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийг 97 хувьтай үнэлж төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Харьяа хүрээлэнгүүдийн залруулагдаагүй нийт зөрчил бидний тогтоосон материаллаг байдлаас 511.6 сая төгрөгөөр хэтэрсэн, 12,640.5 сая төгрөгийн 211 төслийн хугацаа 2016-2019 онд дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч, санхүүжүүлэгчид төслийн болон санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй, улсын дугаар авч бүртгэгдээгүй байгаа зэрэг зөрчлүүд нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.1.6, 8.1.8, Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмийн 3.1.2, Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журмын 8.4, 9.1 дэх заалтуудтай зөрчилдөж санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэн зөв баталж мэдэгдлийг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд сангийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Сангийн захирал нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 он	2020 он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	23,508,724.2	17,183,808.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	265,411.8	176,227.6
33	АВЛАГА	1,101,796.1	1,027,018.1
34	УРЬДЧИЛГАА	20,004,383.0	14,253,659.1
35	БАРАА МАТЕРИАЛ	2,137,133.3	1,726,903.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	49,936,003.1	49,146,318.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	49,936,003.1	49,146,318.1
39200	Биет хөрөнгө	25,991,166.9	25,191,380.4
39300	Биет бус хөрөнгө	23,944,836.2	23,954,937.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	73,444,727.3	66,330,126.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	407,240.6	362,644.4
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	114,828.2	86,225.2
41300	Өглөг	114,675.8	85,770.7
41400	Урьдчилж орсон орлого	152.4	454.5
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	292,412.4	276,419.2
42200	Урт хугацаат зээл	292,412.4	276,419.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	73,037,486.7	65,967,482.1
51	Засгийн газрын хувь оролцоо	73,037,486.7	65,967,482.1
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,305,846.9	38,305,846.9
51200	Хуримтлагдсан үр дүн	20,738,394.8	13,671,958.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,993,245.1	13,989,676.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	73,444,727.3	66,330,126.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 он	2020 он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	32,329,265.7	24,874,951.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,148,142.3	3,826,281.0
120	Нийтлэг татварын бус орлого	8,032,464.6	3,489,228.4
122	Тусламжийн орлого	115,677.7	337,052.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,181,123.4	21,048,670.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	20,878,378.3	31,722,463.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,878,378.3	31,722,463.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,557,674.1	30,567,998.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,096,294.5	11,141,705.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,146,565.6	1,322,318.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	783,429.4	747,370.7
2104	Хангамж, бараа материалын зардал	454,124.2	367,503.5
2105	Нормативт зардал	417,204.7	401,905.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	166,398.3	241,925.4
2107	Томилолт, зочны зардал	429,811.3	184,474.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,732,651.1	9,083,487.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,331,195.0	7,077,306.9
211	ХҮҮ	5,803.6	8,916.8
212	ТАТААС	1,320.4	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	313,580.2	1,145,549.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	11,450,887.4	(6,847,512.4)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	196,008.8	130,561.2
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	40.5	279,898.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,646,855.7	(6,996,849.5)

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2019 он	2020 он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	27,907,074.5	23,641,649.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,443,708.8	2,385,867.0
120	Нийтлэг татварын бус орлого	3,417,771.0	2,385,467.0
122	Тусламжийн орлого	25,937.8	400.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	24,463,365.7	21,255,782.5
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,380,670.7	23,467,728.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,380,670.7	23,467,728.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,889,408.5	22,000,779.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,049,263.0	11,102,576.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,244,187.9	1,348,766.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	772,116.3	771,558.4
2104	Хангамж, бараа материалын зардал	390,126.2	411,936.2
2105	Нормативт зардал	372,719.8	493,559.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	222,431.5	267,470.9
2107	Томилолт, зочны зардал	453,410.5	181,820.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,940,250.8	3,942,700.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,444,902.6	3,480,390.5
211	ХҮҮ	5,803.6	8,916.8
212	ТАТААС	2,342.3	371.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	483,116.3	1,457,661.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	526,403.8	173,920.9
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	398,175.8	263,105.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	398,175.8	263,105.1
2200	Дотоод эх үүсвэрээр	398,175.8	263,105.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(398,175.8)	(263,105.1)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(40,477.8)	0.0
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	40,477.8	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	87,750.2	(89,184.2)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,661.6	265,411.8
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	265,411.8	176,227.6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	ЗГХО-ны дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,418,167.6	0.0	61,418,167.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,880.2)	0.0	(2,880.2)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,415,287.4	0.0	61,415,287.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(5,358.2)	0.0	(5,358.2)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(19,298.2)	0.0	(19,298.2)
9	Тайлант үеийн үр дүн	11,646,855.7	0.0	11,646,855.7
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	73,037,486.7	0.0	73,037,486.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	73,037,486.7	0.0	73,037,486.7
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(69,586.8)	0.0	(69,586.8)
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	72,967,900.0	0.0	72,967,900.0
19	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,568.4)	0.0	(3,568.4)
19	Тайлант үеийн үр дүн	(6,996,849.5)	0.0	(6,996,849.5)
20	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	65,967,482.1	0.0	65,967,482.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,977,609,400.00	13,470,131,513.46	507,477,886.54	96.4
УРСГАЛ ЗАРДАЛ	13,977,609,400.00	13,470,131,513.46	507,477,886.54	96.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,212,906,000.00	12,720,691,414.18	492,214,585.82	96.3
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,162,817,800.00	8,128,674,746.68	34,143,053.32	99.6
Үндсэн цалин	6,264,667,900.00	6,896,163,443.69	(631,495,543.69)	110.1
Нэмэгдэл	1,651,123,100.00	992,899,193.85	658,223,906.15	60.1
Унаа хоолны хөнгөлөлт	246,026,800.00	226,746,202.14	19,280,597.86	92.2
Урамшуулал	1,000,000.00	12,865,907.00	(11,865,907.00)	1,286.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,063,541,000.00	980,502,616.76	83,038,383.24	92.2
Тэтгэврийн даатгал	737,496,800.00	723,767,625.99	13,729,174.01	98.1
Тэтгэмжийн даатгал	81,412,000.00	68,229,392.20	13,182,607.80	83.8
ҮОМШӨ-ний даатгал	65,235,100.00	56,137,141.15	9,097,958.85	86.1
Ажилгүйдлийн даатгал	16,308,800.00	10,098,712.02	6,210,087.98	61.9
Эрүүл мэндийн даатгал	163,088,300.00	122,269,745.40	40,818,554.60	75.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	607,569,500.00	575,226,494.70	32,343,005.30	94.7
Гэрэл, цахилгаан	231,375,400.00	227,518,437.47	3,856,962.53	98.3
Түлш, халаалт	167,272,200.00	137,272,480.59	29,999,719.41	82.1
Цэвэр, бохир ус	62,616,700.00	63,730,376.64	(1,113,676.64)	101.8
Байрны түрээс	146,305,200.00	146,705,200.00	(400,000.00)	100.3
Хангамж, бараа материалын зардал	98,886,900.00	84,852,685.74	14,034,214.26	85.8
Бичиг хэрэг	9,395,900.00	6,894,800.00	2,501,100.00	73.4
Тээвэр, шатахуун	9,129,700.00	8,954,200.00	175,500.00	98.1
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,766,000.00	39,694,106.74	1,071,893.26	97.4
Ном, хэвлэл	6,773,300.00	4,704,200.00	2,069,100.00	69.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,998,700.00	1,968,700.00	30,000.00	98.5
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,823,300.00	22,636,679.00	8,186,621.00	73.4
Нормативт зардал	4,856,200.00	4,850,700.00	5,500.00	99.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,856,200.00	4,850,700.00	5,500.00	99.9
Эд хогшил, урсгал засварын зардал	3,260,000.00	1,378,000.00	1,882,000.00	42.3
Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	418,000.00	382,000.00	52.3
Урсгал засвар	2,460,000.00	960,000.00	1,500,000.00	39.0
Томилолт, зочны зардал	3,210,000.00	3,210,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	3,210,000.00	3,210,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,262,564,600.00	2,937,089,557.80	325,475,042.20	90.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,227,683,000.00	2,902,709,253.80	324,973,746.20	89.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	16,413,000.00	16,413,000.00	-	100.0
Даатгалын үйлчилгээ	493,400.00	434,000.00	59,400.00	88.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,876,100.00	1,771,124.00	104,976.00	94.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	122,000.00	119,000.00	3,000.00	97.5
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,578,400.00	2,578,400.00	-	100.0
Газрын төлбөр	13,348,700.00	13,033,700.00	315,000.00	97.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	31,080.00	18,920.00	62.2
Бараа үйлчилгээний бусад зардал	6,200,000.00	4,906,612.50	1,293,387.50	79.1
Бараа үйлчилгээний бусад зардал	700,000.00	700,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,500,000.00	4,206,612.50	1,293,387.50	76.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	764,703,400.00	749,440,099.28	15,263,300.72	98.0
Бусад урсгал шилжүүлэг	764,703,400.00	749,440,099.28	15,263,300.72	98.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	746,389,900.00	731,582,849.28	14,807,050.72	98.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал	18,313,500.00	17,857,250.00	456,250.00	97.5

урамшуулал				
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,977,609,400.00	13,470,130,723.46	507,478,676.54	96.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,977,609,400.00	13,470,130,723.46	507,478,676.54	96.4
Улсын төсвөөс санхүүжих	13,977,609,400.00	13,470,130,723.46	507,478,676.54	96.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	790.00	790.00	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,211	1,211		100.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	11	11		100.0
Төсвийн байгууллага	11	11		100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	600	600		100.0
Удирдах ажилтан	11	11		100.0
Гүйцэтгэх ажилтан	493	492	1	99.8
Үйлчлэх ажилтан	96	97	1	101.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	600	600		100.0
ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	479	476	(3)	99.4
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	2	2		100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	119	122	3	102.5

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	(төгрөгөөр) ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,868,673,856.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,854,266,052.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,523,341,824.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,152,346.13
210101	Үндсэн цалин	783,960,240.13
210102	Нэмэгдэл	4,562,106.00
210105	Гэрээт ажлын хөлс	630,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	88,143,501.50
210201	Тэтгэврийн даатгал	88,143,501.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,305,581.00
210301	Гэрэл, цахилгаан	5,266,066.00
210302	Түлш, халаалт	150,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,389,515.00
210304	Байрны түрээс	1,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	247,890,732.64
210401	Бичиг хэрэг	50,287,155.00
210402	Тээвэр, шатахуун	125,009,642.34
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,295,025.30
210404	Ном, хэвлэл	7,372,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,360,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,566,710.00
2105	Нормативт зардал	114,898,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	91,309,230.00
210502	Хоол, хүнс	17,962,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,626,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	306,634,481.90
210601	Багаж, техник, хэрэгсэл	133,774,796.90
210602	Тавилга	9,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	6,198,100.00
210604	Урсгал засвар	156,861,585.00
2107	Томилолт, зочны зардал	127,537,435.00
210702	Дотоод албан томилолт	122,537,435.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,469,346,791.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,467,631,301.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,100,000.00
210807	Газрын төлбөр	615,490.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,369,432,825.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,165,104.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,349,267,721.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	330,924,227.64
2132	Бусад урсгал шилжүүлэг	337,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	337,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	330,586,727.64
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг	330,586,727.64
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,407,804.00
2200	Дотоод эх үүсвэрээр	14,407,804.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,407,804.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,868,673,856.61
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	5,868,673,856.61
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,309,629,657.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	519,490,132.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,038,054,067.01

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг сангийн захирал М.Тунгалаг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүгнэлтэд үндэслэсэн шалгагдагч этгээдийн орон тоо, цалин нэмэгдэл, төлбөрийн цахим баримтын бүрдэл, гэрээт ажлын гүйцэтгэлийн талаарх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-аас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, сангийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын аудитын менежер С.Нацагдорж анхан шатны чанарын хяналт хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Сэржмядаг, аудитор Ч.Дашдаваа, Н.Нямсүрэн нар гүйцэтгэв.

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 2/25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 18 дугаар зүйлд Шинжлэх ухаан, технологийн сан нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон инновацын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай байна, 18.3-д Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхээр тус тус заасан байна. Үүнд:

- ✚ Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа хийх;
- ✚ Засгийн газрын /улсын/ захиалгатай шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхэд тэтгэлэг олгох;
- ✚ Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх;
- ✚ Инновацын төсөл хэрэгжүүлэх, гарааны санхүүгийн дэмжлэг олгох, технологи, үйлдвэрлэлийн туршилт, зүгшрүүлэлтэд дэмжлэг үзүүлэх;
- ✚ Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх;
- ✚ Шинжлэх ухаан, инновацын үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсад сурталчлах, борлуулахад дэмжлэг үзүүлэх.

Шинжлэх ухаан, технологийн сан үйл ажиллагааны эрхэм зорилгоо Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн, олон улсын жишигт нийцсэн ахисан түвшний бүтээлч судалгааг тогтмол санхүүжүүлэх замаар Монгол улсын тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна гэж тодорхойлсон байна.

Шинжлэх ухаан, технологийн сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✚ Тухайн жилд Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн болон инновацын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;
- ✚ Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр батлагдсан төслийн санхүүжүүлж, олгосон хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, санхүүгийн тайлан тэнцлийг гаргуулан авч дүн шинжилгээ хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах;
- ✚ Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт хийх, хяналт тавих, үр дүнг тооцох, олгосон хөрөнгийг эргүүлэн төлүүлэх арга хэмжээ авах;
- ✚ Төслийн захиалагч, гүйцэтгэгч байгууллагатай төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжиж дууссан төслийн бүртгэл хөтлөх;
- ✚ Төслийн хэрэгжилтийн явц, санхүүжилтийн талаарх мэдээллийг захиалагчтай хамтран хагас жил тутамд гаргах, дүнг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, нийтэд мэдээлэх.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шинжлэх ухаан, технологийн сан нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг 2015 онд боловсруулагдсанаас хойш нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчилж сайжруулаагүй байна.

Мөн харьяа хүрээлэнгүүд нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант онд “Онол арга зүй” төрийн бус байгууллагаар үйл ажиллагааны онцлогт тохирох НБББББ боловсруулахад хууль эрх зүй, бүртгэлийн стандартын хүрээнд чиглүүлэх сургалт явуулж, хяналт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 2020 оны 8 сард 43 хоногийн хугацаатай байгуулсан боловч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулаагүй нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх үр дагавартай байна.

Шинжлэх ухаан, технологийн сангийн Захиргаа хяналт шинжилгээний хэлтэс, санхүүгийн аудитор нар тайлант онд харьяа 11 хүрээлэнгийн санхүүгийн үйл ажиллагаа болон Зэхэц ажлын төслийн авлага барагдуулах, шилэн данс, төслийн явц, үр дүнд дотоод аудит хийж санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 52 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг авч 5 хүрээлэн, аппаратын бүтэц орон тоо, цалин нэмэгдэл, албан хэрэг хөтлөлт, санхүүгийн тайлагнал, хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн 52 зөвлөмжийн биелэлтийг 92 хувьтай, Зэхэц ажлын авлага барагдуулах талаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 81 хувьтай гэж тус тус үнэлсэн байна.

Мөн шилэн дансны хяналт шалгалтаар хугацаа хоцроож байршуулсан 203 мэдээллийн зөрчлийг арилгах зөвлөмжийн биелэлтийг 94.2 хувьтайгаар үнэлжээ.

Тус сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад үр нөлөөгүй байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 30,445.0 сая төгрөгийн 1 хувь буюу 304.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг аудитын хугацаанд залруулсан 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 32,002.4 сая төгрөгийн 1 хувь буюу 320.0 сая төгрөгөөр дахин тооцлоо.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 265.4 сая, эцсийн үлдэгдэл 176.2 сая төгрөг болж, 89.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Арилжааны банк дахь харилцах	265.4	176.2	(89.2)	100
Дүн	265.4	176.2	(89.2)	100

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 176.2 сая төгрөг нь Дулаан техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн ТӨҮГ 121.3 сая төгрөг, Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн харьяа Агро бизнесийн сургуулийн 54.9 сая төгрөгийн арилжааны банкны дансны үлдэгдэл байна.

Аудитын илрүүлэлт:

Нийт 187.7 сая төгрөгийн худалдан авалт цахим анхан шатны баримтаар нотлогдоогүй /Шинжлэх ухаан, технологийн сан 82.5 сая, Цөмийн физикийн хүрээлэн 10.2 сая, Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн 1.8 сая, Уламжлалт анагаах ухааны хүрээлэн 18.0 сая, Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэн 5.8 сая, Цөм физик судалгааны хүрээлэн 10.1 сая, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн 50.6 сая, Анагаах ухааны хүрээлэн 8.7 сая төгрөг/

Цалин нэмэгдлийг илүү олгосон, ХХОАТ, НДШ суутгаагүй, НДШ-ийг гүйлгэж тайлагнасан, хөнгөлөлт илүү тооцсон, давхар ажил эрхэлсэн зэрэг нийт 90.5 сая төгрөг /Уул уурхайн хүрээлэн 55.9 сая, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн 1.5 сая, Ургамал газар тариалангийн хүрээлэн 20.3, Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн 3.8 сая төгрөг, Цөмийн физик судалгааны хүрээлэн 9.0 сая/

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 103 мэдээллийг хугацаа хоцроож, 23 мэдээллийг огт байршуулаагүй /Шинжлэх ухаан, технологийн сан, Цөмийн физик судалгааны хүрээлэн, Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн, Ургамал газар тариалангийн хүрээлэн, Анагаах ухааны хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн/

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 1,101.8 сая, эцсийн үлдэгдэл 1,027.0 сая төгрөг болж, 74.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	15.2	14.4	(0.8)
Төлбөртэй үйлчилгээний авлага	500.6	401.7	(99.0)
Татаас, санхүүжилтийн авлага	170.1	312.2	142.0
АВЛАГА	686.0	728.2	42.2
Байгууллагаас авах авлага	329.0	248.2	(80.8)
Хувь хүмүүсээс авах авлага	86.8	50.6	(36.2)
Бусад авлага	415.8	298.8	(117.0)
Дүн	1,101.8	1,027.0	(74.8)

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны үлдэгдэлд төслийн авлага 401.5 сая, нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлж, Сангийн яамнаас буцаан авахаар тооцсон авлага 312.2 сая, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн харьяа сургуулийн сургалтын төлбөрийн авлага 39.5 сая, гарааны компаниас авах авлага 33.4 сая, иргэд, аж ахуй нэгж байгууллагаас авах ногооны үр, будааны үнэ, гэрээт ажил, материалын тооцооны авлага 134.8 сая нийт 207.7 сая төгрөг, НДШ, ХХОАТ-ын илүү төлөлт 14.1 сая, бусад авлага 91.5 сая төгрөг тус тус байна.

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 546.5 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Шинжлэх ухаан, технологийн сангаас 2002-2012 онд Зэхэц ажлын санхүүжилтэд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон шүүхээр шийдвэрлэгдсэн 3 төслийн 94.6 сая, шүүхийн шатанд 2 төслийн 73.4 сая, эрэн сурвалжилж байгаа 7 төслийн 233.5 сая, нийт 12 төслийн 401.5 сая төгрөг;
- Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн 2016-2019 онд үүссэн хугацаа хэтэрсэн хүнсний ногоо, суулгац, материал, шатахуун, цалингийн тооцоо гэх мэт байгууллагаас авах 64.6 сая төгрөг, хувь хүнээс авах 32.8 сая төгрөг;
- Уламжлалт анагаах ухааны хүрээлэнгийн 2014 оноос өмнө үүссэн эзэн холбогдогч нь гадаадад байгаа 0.3 сая төгрөг, арбитрын шүүхийн шийдвэртэй эмийн тооцооноос үүссэн “Новая Азия” ХХК-аас авах 38.6 сая төгрөг;
- Уул уурхайн хүрээлэн ТЭЗҮ хийх гэрээний үүргээ биелүүлээгүйгээс “Амгуулин” ХХК-аас авах 14.0 сая төгрөг;
- Мал аж ахуйн, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн 2014 оноос өмнө үүссэн ноолуурын авлага нийт 8.9 сая төгрөг.

Эдгээр нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, хууль журам хэрэгжихгүйгээс авлагын насжилт нэмэгдэх, найдваргүй авлага өсөх үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт: сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт авлагын 53 хувь буюу 546.5 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 28 хувь буюу 285.5 сая төгрөгийн авлага тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 20,004.4 сая, эцсийн үлдэгдэл 14,253.7 сая төгрөг болж, 5,750.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	19,982.7	14,222.1	(5,750.7)
Урьдчилгаа тооцоо	21.7	31.5	9.8
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	2.6	12.5	9.9
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	19.0	19.0	0.0
Дүн	20,004.4	14,253.7	(5,750.7)

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд төслийн санхүүжилтийг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 14,222.1 сая, үндсэн хөрөнгө, бараа ажил, үйлчилгээний төлбөр 31.5 сая төгрөгийн үлдэгдэл байна. Үүнд:

- Сангийн санхүүгийн тайланд 2016-2020 онд иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, ХХК, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудад олгосон 379 төслийн санхүүжилт 12,401.3 сая төгрөг, бусад гэрээт ажлын урьдчилгаа 45.4 сая төгрөг;
- Сангаас авсан төслийн санхүүжилтээ харьяа 8 хүрээлэн нь урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн 49 төслийн 1,787.9 сая төгрөг;
- Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ХХААХҮЯ-ны Баруун бүсийн тодотгох судалгаа төслийн санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл 31.8 сая төгрөг;

Төслийн хугацаа дуусаж санхүүжүүлэгч болон захиалагчид төслийн үр дүн, санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй 145 төслийн 6,549.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлын үлдэгдэл байгаа нь хууль, журам хэрэгжихгүй байх, төсөл үр дүнгүй болох, төслийн зарцуулалтад тавих хяналт сул, санхүүгийн тайланд олон жилийн насжилттай урьдчилж гарсан зардал ихсэх муу үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт: Төслийн урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 13,107.5 сая төгрөгийг санхүүгийн программд төслийн нэр, санхүүжилт, гүйцэтгэгч тус бүрээр салгаж бүртгээгүй /Шинжлэх ухаан, технологийн сан 12,401.3 сая, Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн 500.8 сая Цөмийн физик судалгааны хүрээлэн хэрэгжиж дуусаагүй 4 төслийн нийт 50.8 сая төгрөг/

3.5.6 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 2,137.1 сая, эцсийн үлдэгдэл 1,726.9 сая төгрөг болж, 410.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	720.3	599.1	(121.2)
Тусгай зориулалттай материал	401.5	177.0	(224.5)
Эм боох материал	28.5	57.4	28.8
Дуусаагүй үйлдвэрлэл	9.8	3.9	(5.9)
Бэлэн бүтээгдэхүүн	280.5	360.9	80.4
Хангамжийн материал	1,416.9	1,127.8	(289.1)
Бичиг хэргийн материал	143.6	119.9	(23.6)
Аж ахуйн материал	516.1	238.6	(277.5)
Сэлбэг хэрэгсэл	50.2	28.6	(21.6)
Түлш, шатах тослох материал	2.6	11.3	8.6
Барилгын засварын материал	95.5	40.6	(54.9)
Хүнсний материал	12.2	21.4	9.2
Бусад хангамжийн материал	251.0	360.2	109.2
Мал амьтад	345.7	307.2	(38.5)
Дүн	2,137.1	1,726.9	(410.2)

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал данс 410.2 сая төгрөгөөр буурсан нь төсвийн болон, өөрийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэсэн 1,850.3 сая, гадаад дотоод хандиваар 18.9 сая, малын төл болон нас дэвшилтийн орлогоор 80.5 сая, тооллогоор илэрсэн болон үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлсэн 3.5 сая төгрөг, бусад төсвийн ерөнхийлөн захирагчаас шилжүүлэн авсан 1.9 сая, данс хооронд шилжүүлсэн 316.5 сая, нийт 2,271.6 сая төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант хугацаанд зарцуулсан 2,140.6 сая, ашиглах боломжгүй бараа материалыг акталсан 224.1 сая, үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэн 0.7 сая, данс хооронд шилжүүлсэн 316.5 сая төгрөг нийт 2,681.9 сая төгрөгөөр хасагдсанаас шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт: Бараа материалыг худалдан авч шууд зардлаар бүртгэсэн, ашиглалтгүй материалууд бүртгэлтэй, төлбөрийн баримтгүй бараа материалыг санхүүгийн тайланд бүртгэсэн, тодруулга тайланд буруу ангилан бүртгэсэн зэрэг нийт 34.6 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн /Ургамал, газар тариалангийн хүрээлэн 8.1 сая, Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэн 4.7 сая, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн 19.5 сая, Уул уурхайн хүрээлэн 2.3 сая/

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 64,541.8 сая, эцсийн үлдэгдэл 64,604.6 сая төгрөг болж, 62.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	18,234.9	18,388.0	153.1
Авто-тээврийн хэрэгсэл	2,042.5	2,407.7	365.2
Машин тоног төхөөрөмж(компьютер)	17,099.5	16,734.1	(365.4)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,646.2	1,482.4	(163.9)
Зам, гүүрийн байгууламж	18.9	18.9	-
Бусад үндсэн хөрөнгө	1,236.1	1,301.7	65.6
Ном	210.1	212.7	2.6
Биет хөрөнгө	40,488.3	40,545.6	57.2
Программ хангамж	157.7	166.0	8.2
Бусад биет бус хөрөнгө	23,895.7	23,893.1	(2.6)
Биет бус хөрөнгө	24,053.4	24,059.0	5.6
Дүн	64,541.8	64,604.6	62.8

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө данс 62.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдан авч бэлтгэсэн 263.1 сая, өмнөх оны авлагаар нэмэгдсэн 42.0 сая, ТЕЗ-аас шилжүүлэн авсан 131.1 сая, бусад ТЕЗ-аас шилжүүлэн /ХХААХҮЯ, БОАЖЯ/ авсан 713.9 сая, гадаад дотоод хандиваар 315.8 сая, тооллогоор илэрсэн болон бараа материалын данснаас шилжүүлэн авсан 2.6 сая төгрөг, хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээгээр 42.3 сая, данс хооронд шилжүүлсэн 0.8 сая төгрөг нийт 1,511.6 сая төгрөгөөр нэмэгдсэн. Тайлант хугацаанд акталж данснаас хассан 1,378.2 сая, бусад ТЕЗ-ийн харьяа ТӨҮГ-т шилжүүлсэн 68.7 сая, данс хооронд болон бараа материалд шилжүүлсэн 1.9 сая төгрөг нийт 1,448.8 сая төгрөг хасагдсанаас тус тус шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт: Өмнөх зөвлөмжөөр өгсөн биет бус хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй, худалдан авсан хөрөнгө, бараа материалаа дутуу бүртгэсэн, суудлын автомашин худалдан авахдаа ТБӨӨХБАҮХА тухай хуулийг мөрдөөгүй, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг санхүүгийн программд илүү тооцсон, анхны өртгөө нөхсөн хөрөнгө бүртгэлтэй нийт 502.4 сая төгрөг /Ургамал газар тариалангийн хүрээлэн 24.8 сая, Мал аж ахуй эрдэм шинжилгээний хүрээлэн 59.6 сая, Уламжлалт анагаах ухааны 418.0 сая/

3.5.8 Өр төлбөр

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 407.2 сая, эцсийн үлдэгдэл 362.6 сая төгрөг болж, 44.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	114.8	86.2	(28.6)
Ажилчидтай холбогдсон өглөг	57.8	19.8	(37.9)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	25.0	8.3	(16.7)
Бусад өглөг	32.0	57.7	25.7
Байгууллагад төлөх өглөг	20.0	47.0	27.0
Хувь хүмүүст төлөх өглөг	12.0	10.7	(1.3)
Урьдчилж орсон орлого	0.2	0.5	0.3
Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	0.2	0.5	0.3

УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	292.4	276.4	(16.0)
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	0.0	276.4	276.4
Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл	179.1	0.0	(179.1)
Төслийн зээл	113.3	0.0	(113.3)
НИЙТ ДҮН	407.2	362.6	(44.6)

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт өр төлбөрийн үлдэгдэл 362.6 сая төгрөгөөс төслийн зээлийн өглөг 288.3 сая, цалин, НДШ, ХХОАТ-ын 15.6 сая, худалдан авалттай холбоотой 36.9 сая, хувь хүнд өгөх болон бусад өглөг 21.8 сая төгрөг байна.

Үүнээс богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд олон жилийн насжилттай Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн ХХААХҮЯ-ны харьяа ХААДС-д өгөх төслийн зээлийн өглөг 12.0 сая төгрөг, өмнөх удирдлагуудад өгөх 2016 онд үүссэн 7.1 сая төгрөг, хувь хүнд өгөх 3.8 сая нийт 22.9 сая төгрөг.

Мөн Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Дорнод салбар ХХААХҮЯ-ны харьяа ХААДС-аас авсан жимсний суулгац үржүүлгийн далан байгуулах төслийн урт хугацаат зээл 107.5 сая, хүлэмжийн тоног төхөөрөмжийн урт хугацаат зээл 5.8 сая төгрөг нийт 113.3 сая төгрөг нь ХААДС-ийн санхүүгийн тайланд бүртгэлгүйгээс тооцоо нийлэх боломжгүй, зээлээр авсан тоног төхөөрөмж данс бүртгэлд байхгүй, шүүхийн маргаантай гэх шалтгаанаар хугацаа хэтэрсэн байна.

Аудитын илрүүлэлт: сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн 37.5 хувь буюу 136.2 сая төгрөгийн өглөг хугацаа хэтэрсэн, 35 хувь буюу 128.3 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн 187.0 сая төгрөгийг тооцоо нийлсэн акт үйлдэн хүлээн зөвшөөрсөн боловч 93.0 сая төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр бүртгээгүй, Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн санхүүгийн тайланд өглөгийг 9.5 сая төгрөгөөр дутуу тусгасан байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 73,037.5 сая, эцсийн үлдэгдэл 65,967.5 сая төгрөг болж, 7,070.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо				/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38,305.8	38,305.8	-	58.1
Хуримтлагдсан үр дүн	20,738.4	13,672.0	(7,066.4)	20.7
Өмнөх үеийн үр дүн	9,091.5	20,668.8	11,577.3	31.3
Тайлант үеийн үр дүн	11,646.9	(6,996.8)	(18,643.7)	(10.6)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	13,993.2	13,989.7	(3.6)	21.2
Дүн	73,037.5	65,967.5	(7,070.0)	100.0

Эх сурвалж: ШУТС-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 65,967.5 сая төгрөг болж 7,070.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 13,989.7 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр буурсан нь Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн дахин үнэлгээтэй хөрөнгө акталж данснаас хассанаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн 13,672.0 сая төгрөг болж 7,066.4 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт данс алдааны залруулгаар 69.6 сая төгрөгөөр буурсан, тайлант оны үр дүн 18,643.7 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд шүүхийн

шийдвэрээр хэрэгсэхгүй болсон төслийн авлага 65.9 сая, өмнөх онд улсын төсөвт төвлөрүүлэх төсвийн дутуу зарцуулалтыг авлагаар бүртгэсэн 14.2 сая нийт 75.1 сая төгрөгөөр авлагыг бууруулж, НДШ, ХХОАТ-ын тооцооны зөрүүгээр 7.1 сая, дахин үнэлгээтэй хөрөнгө акталсан 3.6 сая төгрөгөөр нэмэгдүүлснээс шалтгаалж бүртгэгдсэн 69.6 сая төгрөгийн алдааны залруулга байна.

3.5.10 Орлогын данс

Орлого үр дүнгийн тайлангаар улсын төсвийн санхүүжилтээр 13,677.6 сая, тусгай сангаас 109.4 сая, нэмэлт санхүүжилтээр 5,101.8 сая, гадаад дотоод хандив тусламжийн орлого 337.1 сая, үндсэн үйл ажиллагааны орлого 1,995.9 сая, туслах үйл ажиллагааны орлого 564.5 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 977.1 сая, түрээсийн орлого 47.4 сая, бусад орлого 2,219.7 сая, нийт 25,030.5 сая төгрөгийн орлогыг тайлагнасан байна.

3.5.11 Зардлын данс

Орлого үр дүнгийн тайлангаар цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 12,629.7 сая, байр ашиглалтын зардалд 747.4 сая, хангамж, эд хогшлын зардалд 241.9 сая, томилолтын зардалд 184.5 сая, бараа үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлсэн ажлын 15,996.7 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 846.5 сая, бусад зардалд болон үйл ажиллагааны бус зардалд 314.6 сая, төвлөрүүлэх шилжүүлэг 273.1 сая төгрөгийг тайлагнасан байна.

Аудитын илрүүлэлт:

-Дулаан техник, үйлдвэрлэл экологийн хүрээлэн түрээсийн гэрээний төлбөрөөс 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй; ажил гүйцэтгэсэн гэрээг дутуу дүгнэж 65.0 сая төгрөгийг зардлаар бүртгэсэн;

-Ургамал хамгаалал, эрдэм шинжилгээний хүрээлэн өмгөөллийн үйлчилгээний хөлсөнд 2.5 сая төгрөгийг зориулалт бус зардал гаргасан

-Уламжлалт анагаах ухааны хүрээлэн жолоочийн тооцооны хүснэгтийг үндэслэн тооцоо бодсон акт үйлдээгүй нормоос хэтрүүлэн шатахуун зарцуулсан 85.7 сая төгрөг байна.

Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн томилолтын хуудасгүй 28.1 сая, шатахууны тооцоог бодоогүй 17,1 сая төгрөгийн зөрчлүүд байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 74,236.8 сая төгрөгөөр тус тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сангийн хүргүүлсэн төсвийн төслөөс 135.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 74,372.3 сая төгрөгөөр ТЕЗ-д санал хүргүүлсэн боловч 52,076.1 сая төгрөгөөр бууруулж 22,295.4 сая төгрөгөөр баталсан байна.

Мөн тодотгосон төсвөөр нийт зардлыг 8,317.8 сая төгрөгөөр бууруулсан нь Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, тухай хуультай холбоотойгоор төслийн санхүүжилт, болон урсгал зардлууд буурсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тус сангийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан төслийн санхүүжилтэд 2,800.0 сая, урсгал зардалд 11,177.6 сая төгрөгийг зарцуулахаар улсын төсвөөс 13,977.6 сая төгрөгийг санхүүжүүлэхээр батлагджээ. Үүнээс

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 13,677.6 сая, туслах үйл ажиллагааны орлогоос 47.2 сая төгрөг нийт 13,724.8 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 13,470.1 сая төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 254.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 13,470.1 сая төгрөг буюу 96.4 хувьтай байгаа нь улсын батлагдсан төсвийг 600.0 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой ба дараах материаллаг дүнтэй дутуу зарцуулалт гарсан зардлууд байна. Үүнд:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 117.1 сая төгрөг;
- Байр ашиглалттай холбоотой зардал 32.3 сая төгрөг
- Хангамжийн материалын зардал 14.0 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 325.5 сая төгрөг.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад төсөл хөтөлбөрийн санхүүжүүлэгч 14 байгууллагаас 1,309.6 сая, Засгийн газрын нөөц сангаас 1.5 сая, дээд шатны төсвийн захирагчаас 519.6 сая, бусад 4 ТЕЗ-аас 2,666.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,371.7 сая, нийт 5,868.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 877.3 сая, байр ашиглалтын зардалд 10.3 сая, бараа материал, эд хогшил, нормативт зардалд 669.4 сая, томилолт 127.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, бараа үйлчилгээний бусад зардалд 3,853.6 сая, нийт 5,538.1 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 330.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Улсын төсөвт төвлөрүүлсэн 330.6 сая төгрөгөөс 18.4 сая төгрөгийг улсын төсвийн орлогод тооцуулж, 312.2 сая төгрөгийг буцаан авахаар Сангийн яамнаас авлага үүсгэн бүртгэсэн байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 133 мэдээллээс 130 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 39.0 сая төгрөгийн 7 төлбөрийн акт, 64.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага, 803.5 сая төгрөгийн 39 зөвлөмж хүргүүлснээс биелэлт 92.0 хувьтай байна.

Хүснэгт 8 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	7	39.0	7	39.0			100
Албан шаардлага	6	64.3	6	64.3			100
Зөвлөмж	39	803.5	37	803.5	2	0	75
Нийт	52	906.8	50	906.8			92

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Тус сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 10 төсвийн байгууллага, 1 төрийн өмчит үйлдвэрийн газар, 1 тусгай сангийн нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 9 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамруулсан.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 6, “Хязгаарлалттай” 3 (Мал аж ахуй, эрдэм шинжилгээний хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн, Цөмийн физик судалгааны хүрээлэн) байна.

Аудитаар нийт 6,023.2 сая төгрөгийн 85 алдаа, зөрчил илрүүлснээс 4,488.5 сая төгрөгийн 25 алдааг аудитын явцад залруулж, 38.9 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 132.5 сая төгрөгийн 12 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1,363.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 38 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Тус сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 0.2 сая төгрөгөөр авлагыг илүү, 5.4 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийг хөрөнгийг илүү, 42.3 сая төгрөгөөр дахин үнэлгээг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 295.8 сая төгрөгөөр төсөвт байгууллагын өөрийн орлогыг дутуу, 169.9 сая төгрөгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг дутуу, тусламж, санхүүжилтийн орлогыг 523.9 сая төгрөгөөр илүү, 226.4 сая төгрөгөөр хангамж бараа материалын зардлыг илүү, 670.0 сая төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг дутуу, 5.4 сая төгрөгөөр бараа үйлчилгээний зардлыг илүү, 869.4 сая төгрөгөөр нийт үйл ажиллагааны үр дүнг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 594.9 сая төгрөгөөр үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг илүү, 594.9 сая төгрөгөөр нийт зарлага ба цэвэр зээлийг илүү нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа хүрээлэнгүүдэд олгосон төслийн санхүүжилтийн орлого, зардлыг 475.4 сая төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд 520.2 сая төгрөгөөр тус тус устгаж цэвэр дүнгээр тайлагнаагүй байна.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Аудитаар зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 831.6 сая төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлээ.

Тайлант хугацаанд оруулбал зохих 133 мэдээллээс хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл Шилэн дансны зарчим 4.1.3-д тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйл. Шилэн дансны мэдээлэл 6.1. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны байгууллагууд, харьяа хүрээлэн, их сургуулиуд зэрэг байгууллагуудад 12,640.5 сая төгрөгийн, 211 төслийн хугацаа нь 2016-2019 онд дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч болон санхүүжүүлэгчид төслийн тайланг, санхүүгийн тайлантай хамт хүлээлгэж өгөөгүй, улсын дугаар авч бүртгүүлээгүй байна.

Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор баталсан Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журмын 8.4.1-д “захиалсан үр дүн, санхүүжилтийн талаар зохих

журмын дагуу бичсэн төслийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх”, 8.4.2-д “төслийн хүрээнд бий болсон шинжлэх ухааны шинэ мэдлэг (энэ журмын 8.2-т тусгагдсан баримтаар баталгаажсан)-ийн талаар улсын стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг итгэмжлэн хадгалагчид төсөл дууссанаас хойш 3 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх, цалин хөлсний тушаал шийдвэр гэх мэт төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах;

Мөн хугацаа дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч болон санхүүжүүлэгчид төслийн тайланг, санхүүгийн тайлантай хамт хүлээлгэж өгөөгүй, улсын дугаар авч бүртгүүлээгүй 2012-2019 оны хооронд санхүүжилт олгосон 12,640.5 сая төгрөгийн 211 төсөлд гүйцэтгэлийн аудит оруулах шаардлагатай гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Цалингийн зардалтай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

Сангийн баталсан бүтцээр 3 хэлтсийн нийт 24 орон тооноос санхүү, төлөвлөлтийн хэлтсийн 7 ажилтан нь нийт ажилтнуудын 30 хувийг эзэлж байгаа ба сангийн орон тоо, бүтцийг оновчтой хийх шаардлагатай байна. Мөн тайлант онд харьяа 3 хүрээлэн нь батлагдсан орон тоог 26-аар хэтрүүлэн ажилласан байна.

4.1.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэл хангахгүй, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг зөрчсөн байна.

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.

Сангийн орон тоо, бүтцийг оновчтой зохион байгуулах, харьяа хүрээлэнгүүд батлагдсан орон тоонд багтаан ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.2 . Цалингийн зардалтай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

- Салбарын сайдын 2020 оны 6 дугаар сарын 12/3934 дугаар тушаалаар 2019 оны “санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсан байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтнуудад батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшуулал олгож болно” гэсэн байхад сангийн захирлын 2020 оны 4 дүгээр сарын Б/12 дугаар тушаалаар санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт авсан гэх үндэслэлээр 16 ажилтанд 10-90 хувиар тооцож 3.8 сая төгрөгийн урамшуулал олгосон ба урамшуулал олгосон ажилтнууд дотор төсөв, санхүүтэй хамааралтгүй албан тушаалын ажилтан, 2019 оны санхүүгийн жилд бүтэн ажиллаагүй ажилтнуудад олгосон;
- Сангийн захирлын 2020 оны 12 дугаар сарын Б/37 дугаар тушаалаар ажилтнуудад 11.6 сая төгрөгийн урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлж, олгох хувь хэмжээг тогтоолгүй нэг ажилтанд дунджаар үндсэн цалингийн 51.8-92.3 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон байна.

4.2.2 Эрсдэл:

ууль, журам хэрэгжихгүй байх, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглахХ эрсдэлтэй

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Цаашид үр дүнгийн урамшуулал олгохдоо тушаалд үндэслэлийг оновчтой оруулах, үр дүнгийн урамшууллыг сар бүр дүгнэн, улирал бүр олгохдоо нийт үндсэн цалингийн 40 хувиас ихгүй байх ЗГ-ын тогтоолыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.3 Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал

4.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд 51.7 сая төгрөгийн 5 гэрээ байгуулж урьдчилгаанд 30.6 сая төгрөгийг олгосон. Гэрээт ажлуудыг 6-12 дугаар сарын хооронд хүлээж авах байсан боловч ажлууд дуусаагүй урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна. Тус гэрээт ажлуудаас 2020 оны 8 сард "Онол арга зүй" ТББ-аар байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирох НБББББ боловсруулах, хууль эрх зүй, бүртгэлийн стандартын хүрээнд чиглүүлэх сургалт явуулах, хяналт хийх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээг 43 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр байгуулсан боловч гэрээний үүрэг биелэгдээгүй, хийж буй ажлын явц дүгнэгдээгүй, 9.9 сая төгрөгийг зарцуулах захирлын тушаал шийдвэргүй төлбөрийг 100 хувь шилжүүлсэн байна.

4.3.2 Эрсдэл:

Энэ нь үнэн зөв батламж мэдэгдэл хангахгүй, Төсвийн тухай хуулийн зөрчигдөх

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Гэрээт ажлуудыг заасан хугацаанд хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллах, батлагдан төсвийг үр дүнтэй, үр ашигтай зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.4 Зардлын данстай холбоотой асуудал

4.4.1 Илрүүлэлт:

Тайлант онд 215 ААН-тэй хийсэн 548.3 сая төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 82.5 сая төгрөгийн худалдан авалтын /НӨАТ-ын/ төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна.

4.4.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналт сул, анхан шатны баримтгүй ажил гүйлгээ их, хууль, журам мөрдөгдөхгүй байх.

4.4.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтыг зөрчсөн байна. Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах” заалтыг тус тус зөрчсөн байна.

4.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

4.5 Төслийн урьдчилж гарсан зардлын бүртгэлтэй холбоотой асуудал

4.5.1 Илрүүлэлт:

Төслийн санхүүжилтийн урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 12,401.3 сая төгрөгийг санхүүгийн программд төслийн нэр, санхүүжилт, гүйцэтгэгч тус бүрээр ангилан бүртгээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.3 дахь заалтыг зөрчсөн байх.

4.5.2 Эрсдэл:

Төслийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сул, хууль, журам хэрэгжихгүй байх

4.5.3 Өгсөн зөвлөмж:

Төслийн урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 12,401.3 сая төгрөгийг санхүүгийн программд төслийн нэр, санхүүжилт, гүйцэтгэгч тус бүрээр бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх

4.5.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана

4.6. Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал

4.6.1 Илрүүлэлт:

Харьяа газруудын санхүүгийн тайлангийн аудитаар 703.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38.9 сая төгрөгийн 10-н төлбөрийн акт, 132.5 сая төгрөгийн 10-н албан шаардлага, 531.7 сая төгрөгийн 32 зөвлөмж авсан байна.

4.6.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангагдаагүй, дээд шатны удирдлагын дотоод хяналт сул байх.

4.6.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг үнэлэх, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

4.6.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021 он	Аудитын нэр:	Шинжлэх ухаан, технологийн сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
Шалгагдсан байгууллагын нэр:	ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН САН		САГ-2021/18/СТА-ЗГТС
			Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Тайлант хугацаанд оруулбал зохих 133 мэдээллээс хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна		Албан шаардлага	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
2	Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны байгууллагууд, харьяа хүрээлэн, их сургуулиуд зэрэг байгууллагуудад төслийн хугацаа дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч болон санхүүжүүлэгчид төслийн тайланг, санхүүгийн тайлантай хамт хүлээлгэж өгөөгүй, улсын дугаар авч бүртгүүлээгүй 12,640.5 сая төгрөгийн 211 төсөл байна.		Албан шаардлага	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
3	Сангийн баталсан бүтцээр 3 хэлтсийн нийт 24 орон тооноос санхүү, төлөвлөлтийн хэлтсийн 7 ажилтан нь нийт ажилтнуудын 30 хувийг эзэлж байгаа ба сангийн орон тоо, бүтцийг оновчтой хийх шаардлагатай байна. /Жишээ нь төсөл хариуцсан, мөнгөн гүйлгээ төсөв тооцоо, цалин хөлс хөрөнгө хариуцсан гэх 3 нягтлан бодогч ажиллаж байна/ Мөн тайлант онд харьяа 3 хүрээлэн нь батлагдсан орон тоог 26-аар хэтрүүлэн ажилласан байна		Зөвлөмж	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
4	Салбарын сайдын 2020 оны 6 дугаар сарын 12/3934 дугаар тушаалаар санхүүгийн ажилтнуудад батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшуулал олгож болно гэсэн байхад сангийн захирлын 2020 оны Б/12 дугаар тушаалаар 16 ажилтанд 10-90 хувиар тооцож 3.8 сая төгрөгийн урамшуулал олгосон ба урамшуулал олгосон ажилтнууд дотор төсөв, санхүүтэй хамааралтгүй албан тушаалын ажилтан, 2019 оны санхүүгийн жилд бүтэн ажиллаагүй ажилтнуудад олгосон; Сангийн захирлын 2020 Б/37 дугаар тушаалаар ажилтнуудад 11.6 сая төгрөгийн урамшуулал олгохдоо ажлын үр дүнг үнэлж, олгох хувь хэмжээг тогтоолгүй нэг ажилтанд дунджаар үндсэн цалингийн 51.8-92.3 хувьтай тэнцэх мөнгөн урамшуулал олгосон байна	15.4	Зөвлөмж	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
5	Тайлант онд 51.7 сая төгрөгийн 5 гэрээт байгуулж урьдчилгаанд 30.6 сая төгрөгийг	30.6	Зөвлөмж	Захирал, Ерөнхий	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг

	олгосон. Гэрээт ажлуудыг 6-12 сарын хооронд хүлээж авах байсан боловч ажлууд дуусаагүй урьдчилж гарсан зардал дансанд бүртгэлтэй байна. Гэрээг 43 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэхээр байгуулсан боловч гэрээний үүрэг биелэгдээгүй, хийж буй ажлын явцыг дүгнэгдээгүй, захирлын тушаал шийдвэргүй төлбөрийг 100 хувь шилжүүлсэн байна			ня-бо Ерөнхий ня-бо	
6	Тайлант онд 215 ААН-тэй хийсэн 548.3 сая төгрөгийн худалдан авалтыг и-баримттай тулган шалгахад 82.5 сая төгрөгийн худалдан авалтын /НӨАТ-ын/ төлбөрийн цахим баримт гаргуулан аваагүй байна	82.5	Зөвлөмж	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
7	Төслийн урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 12,401.3 сая төгрөгийг санхүүгийн программд төслийн нэр, санхүүжилт, гүйцэтгэгч тус бүрээр бүртгэх		Зөвлөмж	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
8	Харьяа газруудын санхүүгийн тайлангийн аудитаар 703.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 38.9 сая төгрөгийн 10-н төлбөрийн акт, 132.5 сая төгрөгийн 10-н албан шаардлага, 531.7 сая төгрөгийн 32 зөвлөмж авсан байна.	703.1	Зөвлөмж	Захирал, Ерөнхий ня-бо	М.Тунгалаг, С.Оюунтунгалаг
	Дүн	831.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 483/А0160058

Улаанбаатар хот

САГ-2021/18/СТА-ЗГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шинжлэх ухаан технологийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шинжлэх ухаан, технологийн сангаас төслийн санхүүжилт авсан иргэн, аж ахуй нэгж, төрийн бус байгууллага, Шинжлэх ухааны байгууллагууд, харьяа хүрээлэн, их сургуулиуд зэрэг 12,640.5 сая төгрөгийн 211 төслийн хугацаа 2016-2019 онд дууссан боловч төслийн үр дүнг үнэлээгүй, гүйцэтгэгч нь захиалагч, санхүүжүүлэгчид төслийн болон санхүүгийн тайланг хүлээлгэж өгөөгүй, улсын дугаар авч бүртгээгүй байна.

Энэ нь Засгийн газрын 2014 оны 301 дүгээр тогтоолоор батлагдсан "Шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх журам"-ын 8.4.1-д "захиалсан үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн төслийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөх" мөн журмын 8.4.2-т "төслийн хүрээнд бий болсон шинжлэх ухааны шинэ мэдлэг (энэ журмын 8.2-т тусгагдсан баримтаар баталгаажсан)-ийн талаар улсын стандартын дагуу бичсэн эрдэм шинжилгээний ажлын тайланг итгэмжлэн хадгалагчид төсөл дууссанаас хойш 3 сарын дотор цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгөх" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төслийн үр дүн, санхүүжилтийн талаар зохих журмын дагуу бичсэн төслийн тайланг захиалагч, санхүүжүүлэгчид тогтоосон хугацаанд нь хүлээлгэн өгөхөд хяналт тавьж ажиллаж байх, хугацаа дууссан 12,640.5 сая төгрөгийн 211 төслийг журмын дагуу хүлээн авах, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан технологийн сангийн захирал М.Тунгалаг, ерөнхий нягтлан бодогч С.Оюунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР:
АУДИТОР:

Я.САМБУУНЯМ
Б.СЭРЖМЯДАГ
Н.НЯМСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 482/A0160058

Улаанбаатар хот

САГ-2021/18/СТА-3ГТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шинжлэх ухаан технологийн сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 133 мэдээллээс хугацаандаа оруулсан 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийг үнэн зөв, бодитой иж бүрэн байршуулж, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шинжлэх ухаан технологийн сангийн захирал М.Тунгалаг, ерөнхий нягтлан бодогч С.Оюунтунгалаг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР:

АУДИТОР:

Я.САМБУУНЯМ

Б.СЭРЖМЯДАГ

Н.НЯМСҮРЭН

[illegible]

[illegible]